



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 143

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Дорждэрэм овогтой Содгэрэлийн Бэрх 7 дугаар багийн 802г хаягт байрлах Автомашины гаржийн зориулалттай 2304011130 нэгж талбарын дугаар бүхий 31 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Лхагвасүрэн овогтой Батжаргалд шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Л.Батжаргалд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Т.Очирбат/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны а/193 тоот захирамж болон 0000139023 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЖАВХЛАНБАЯР



230423339